40

# ГЕРОНТОЛОГИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2022 оны 11 сарын 12 өдөр Дугаар А/63 Улаанбаатар хот

Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж үнэлэх журам батлах тухай

Төрийн албаны тухай хуулийн зургаадугаар хэсэг, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.4 дэх заалт Геронтологийн үндэсний төвийн хөгжлийн стратеги төлөвлөгөөг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Шинэ эмнэлгийн барилга ашиглалтанд орж байгаатай холбогдуулан Хүний нөөцийн хангалтын тасралгүй, тогтвортой байдлыг бүрдүүлэх, төлөвлөх залгамж халааг бэлдэх, ажилтнуудын нийгмийн баталгаа, сурах боломжийг хангах үйл ажиллагаа бүхий Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж үнэлэх журмыг хавсралтаар батлсугай.

Хоёр. Стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг жил бүр батлуулан хэрэгжилтийг хангаж ажиллахыг Хүний нөөцийн менежер /Н.Үүрцайх/-д даалгасугай.

Гурав. Тушаалын хэрэгжилтийг хянаж, хяналт тавьж ажиллахыг Дэд захирал /Т.Дулмаа/-д үүрэг болгосугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ Р.ХИШИГЖАРГАЛ

УХА0406
5026814 1116 124703

41

Геронтологийн үндэсний төвийн
захирлын 2022 оны 11 сарын 12 өдрийн
А/63 тоот тушаалын 1 хавсралт

УХА0406
5026814 1116 124703

# ХҮНИЙ НӨӨЦИЙН СТРАТЕГИ, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ХЯНАЖ ҮНЭЛЭХ ЖУРАМ

УЛААНБААТАР ХОТ
2022 ОН

**АГУУЛГА**

**НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

1.1 Стратегийн зорилго

1.2 Стратегийн үндэслэл, эрх зүйн орчин

1.3 Стратегийг хэрэгжүүлэх зарчим

1.4 Геронтологийн үндэсний төвийн хүний нөөцийн өнөөгийн байдал, тулгамдсан асуудал

**ХОЁР. ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО**

2.1 Төрөөс баримтлах бодлого

2.2 Геронтологийн үндэсний төвийн хүний нөөцийн бодлого, тэргүүлэх чиглэл

**ГУРАВ. СТРАТЕГИЙН ЗОРИЛТ**

**ДӨРӨВ. Стратегийн хэрэгжилтийг хянаж үнэлэх журам**

Хавсралт 1. Хүний нөөцийн стратеги төлөвлөгөө

Хавсралт 2. Геронтологийн үндэсний төвийн өнөөгийн орон тоо болон шинэ эмнэлэгт шаардлагатай орон тоо

# НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

## 1.1 Зорилго

Хүний нөөцийн бодлогыг оновчтой хэрэгжүүлэх замаар Геронтологи гериатрийн салбарын үйл ажиллагааг олон улсын жишигт ойртуулах мэргэжлийн ур чадвар бүхий ажилтнуудыг бүрдүүлэн тогтвор суурьшилтай сэтгэл хангалуун ажиллах нөхцлийг бүрдүүлж, ажлын байран дээрээ өсөж дэвших боломжоор хангахад оршино.

## 1.2 Үндэслэл, эрх зүйн орчин

МУ-ын Эрүүл мэндийн тухай хуулийн Зургадугаар бүлэг, Эрүүл мэндийн ажилтны нийгмийн хамгааллын үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, "Геронтологийн үндэсний төвийн дунд хугацааны стратеги төлөвлөгөө 2021-2024"-д тусгагдсан Хүний нөөцийн зорилтуудыг хэрэгжүүлэх, төвийн шинэ эмнэлгийн үйл ажиллагааг эхлүүлж өргөжүүлэхэд шаардлагатай хүний нөөцийн хөгжлийг хангах зорилгоор "Хүний нөөцийн хөгжүүлэх стратеги 2023-2026"-ийг боловсруулж хэрэгжүүлэх шаардлага гарч байна.

Стратегийг дараах хууль эрх зүйн баримт бичгүүдийн хүрээнд хэрэгжүүлнэ.

- Монгол Улсын Үндсэн хууль
- Төрийн албаны тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Бусад хууль тогтоомжууд

## 1.3 Стратегийг хэрэгжүүлэх зарчим

- Ил тод байх
- Хууль дээдлэх
- Төрийн бодлогын баримт бичиг, хууль тогтоомжтой уялдсан байх
- Жендерийн тэгш байдлыг хангах
- Эмч эмнэлгийн мэргэжилтний санал санаачлагад тулгуурлах

## 1.4 Стратеги хэрэгжүүлэх хугацаа

Энэхүү стратегийг 2022-2026 оны хугацаанд хэрэгжүүлнэ.

## 1.5 Геронтологийн үндэсний төвийн хүний нөөцийн өнөөгийн байдал, тулгамдсан асуудал

2022 оны 1 сарын байдлаар Геронтологийн үндэсний төв нь нийт 39-н үндсэн ажилтан, 1 гэрээт ажилтантай байна. Мөн хүүхдээ асрах чөлөөтэй 7-н эх байна. Хүний нөөцийн өнөөгийн түвшинд хийсэн судалгааны үр дүнг нэгтгэн, цаашид анхаарах, авч хэрэгжүүлэх шаардлагатай ажил үйл ажиллагааг дараах байдлаар тодорхойлов.

- Геронтологийн үндэсний төвийн үндсэн 39-н ажилтны 53.8 хувь буюу 21-н ажилтан 5 буюу түүнээс дээш ажилласан. 4 жил ажилласан ажилтан байхгүй, 3-н жил ажил ажилласан ажилтан 3 байгаа нь сүүлийн 5-н жилийн хугацаанд шилжилт хөдөлгөөн их байсныг харуулж байна. Энэ нь ажилтнуудыг тогтвор суурьшилтай ажиллуулах нөхцөл боломжоор бүрэн хангах шаардлагатай байгааг харуулж байна.

- Удирдлагын багийн бүрэлдэхүүний зарим гишүүн нь удирдлагын бүрэлдэхүүнд удаагүй, 75 хувь нь удирдах албан тушаалд ажилласан туршлага бага байгаа тул Удирдлагын багийг чадавхижуулах, хөгжил манлайллын сургалтанд тогтмол хамруулах арга хэмжээ авах

- Эрдэм шинжилгээ сургалтын албаны бүрэлдэхүүн нь 2-3-н жилд 100 хувь солигдож байгаа нь тухайн чиглэлийн залгамж, эрдэм шинжилгээний урт хугацааны судалгаа, сургалтын чанар, төрөл сайжрах боломжийг удаашруулж байна.

- Сүүлийн 3-н жилийн байдлаар жилд дунджаар 31 удаагийн дотоод сургалтанд давтагдсан тоогоор 1094, гадаад сургалтанд дунджаар 25-н ажилтан хамрагдаж байгаа нь ажилтнуудад чиглэсэн сургалтын тоо хамрагдалт сайн байгаа боловч сэтгэл ханамжийн судалгаагаар дунд үнэлэгдэж байгаа нь сургалтын төрөл, чанар хангалтгүй байгааг харуулж байна.

- Эрүүл мэндийн байгууллага хагас бие даасан байдал руу шилжиж байгаа үед цаашид баримтлах бодлогын баримт бичиг тодорхойгүй.

- Байгууллагын ажиллах орчны талаарх ажилтнуудын үнэлгээ тогтмол буурах хандлагатай. Ажиллах орчин, шавж халдваргүйтгэл нь тулгамдсан асуудал болсон. Арга хэмжээ авч ажилладаг боловч хувийн эмнэлгийн оролцоо хангалтгүйгээс үр дүн багатай болдог. Ажилтнуудын тогтвор суурьшилтай ажиллахад голлох нөлөө үзүүлдэг асуудал болж байна.

- Шинэ эмнэлгийн барилга ашиглалтанд орохтой холбоотойгоор хүний нөөцийн бэлэн байдал хангагдаагүй байна.

## ХОЁР. ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО

### 2.1 Төрөөс баримтлах бодлого

- Засгийн газрын мөрийн хөтөлбөр

2.1.3.Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулан иргэд эх орондоо оношлогдон, эмчлүүлэх боломжийг нэмэгдүүлж, орчин үеийн үндэсний оношилгоо, эмчилгээний төвүүдийг шинээр байгуулна:

2.1.3.4.Геронтологийн үндэсний төв;

2.5.Нийгмийн даатгалын тогтолцоог шинэчилж, нийгмийн халамжийг оновчтой болгон, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, хүн амын хөгжлийг хангаж, дундаж давхаргын хүрээг өргөжүүлэн монгол хүний амьдралын чанарыг дээшлүүлнэ.

2.5.4.Хөдөлмөрийн зах зээлийг орчин үеийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн шинэчилж, бүтээмж, үр дүнд суурилсан цалин хөлс, ажлын үнэлгээний систем нэвтрүүлж, зайнаас болон цагаар ажиллах уян хатан зохицуулалт бий болгон хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ.

2.5.5.Цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмжийг инфляц, хөдөлмөрийн бүтээмжтэй уялдуулан үе шаттайгаар нэмэгдүүлнэ.

2.5.6."Цахим Монгол" арга хэмжээний хүрээнд хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарыг бүхэлд нь цахимжуулж, иргэдэд үзүүлэх үйлчилгээг ил тод, шуурхай, хүртээмжтэй болгоно.

- Монгол Улсын Их хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан "Алсын хараа 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого" батлах тухай

Зорилт 2.2.Эрүүл дадал хэвшилтэй, идэвхтэй амьдралын хэв маягтай иргэнийг төлөвшүүлэн эрүүл мэндийн чанар, хүртээмж, үр дүнтэй тогтолцоог хөгжүүлнэ. Зорилтыг хэрэгжүүлэх үе шат, хүрэх үр дүн I үе шат (2021-2030): Эрүүл мэндийн чанар, хүртээмжтэй тогтолцооны шинэчлэлийн үе.
1.Иргэн, гэр бүл, ажил олгогчийн оролцоонд тулгуурласан нийгмийн эрүүл мэндийн тогтолцоо бэхэжсэн байна.
2.Нотолгоонд суурилсан орчин үеийн оношилгоо, эмчилгээний техник, технологийн дэвшлийг нэвтрүүлж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, гүйцэтгэлд тулгуурласан санхүүжилт, даатгалын тогтолцоотой болсон байна. 3.Эрүүл мэндийн салбарт цахим үйлчилгээг өргөжүүлэн үндэсний эрүүл мэндийн мэдээллийн сан бүрдсэн байна.

4.Эрүүл мэндийн хүний нөөцийн хангалт, ур чадвар, нийгмийн хамгааллыг сайжруулсан байна

### 2.2 Геронтологийн үндэсний төвийн хүний нөөцийн бодлого, тэргүүлэх чиглэл

- Хүний нөөцийн хөгжлийн оновчтой тогтолцоог бүрдүүлэх
- Геронтологи гериатрийн олон улсын жишгийг байгууллагадаа нэвтрүүлэх
- Ажлын гүйцэтгэлийн удирдлагыг төгөлдөржүүлжэх ажилтнуудын тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэх
- Ажилтанд тогтвор суурьшилтай ажиллах нөхцлийг бүрдүүлэх

## 3. СТРАТЕГИЙН ЗОРИЛТ

| | |
|---|---|
| Стратегийн зорилт 1: | Хүний нөөцийн төлөвлөлт, бүрдүүлэлт, мэргэжлийн залгамж халааг бэлтгэх, тогтвортой ажиллуулах |
| Стратегийн зорилт 2: | Хүний нөөцийн сургалт, хөгжлийн бодлогыг тасралтгүй, үе шаттай хэрэгжүүлэх |
| Стратегийн зорилт 3: | Ажлын гүйцэтгэлийн удирдлага, зохион байгуулалтыг оновчтой болгох |
| Стратегийн зорилт 4: | Цалин хөлс, шагнал, урамшууллын системийг боловсронгуй болгох |
| Стратегийн зорилт 5: | Хөдөлмөрийн аюулгүй байдал, ажиллах нөхцөлийг сайжруулах |
| Стратегийн зорилт 6: | Эрүүл мэндийн ажилтны эрүүл мэндийг хамгаалах |
| Стратегийн зорилт 7: | Ажилтнуудын нийгмийн баталгааг хангах |

## 4. ГЕРОНТОЛОГИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ХҮНИЙ НӨӨЦИЙН СТРАТЕГИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ҮНЭЛЭХ ЖУРАМ

4.1. Геронтологийн үндэсний төвийн хүний нөөцийн стратегийг үнэлэх ажлын хэсэгт Дэд захиралаар ахлуулсан, Стратеги, төлөвлөлтийн албаны дарга, Эмнэлгийн тусламжийн үйлчилгээний албаны дарга, Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлын албаны дарга, Хүний нөөцийн менежер, Хяналт, үнэлгээний мэргэжилтэн, эдийн засагч нар ажиллана.

4.2. Ажлын хэсэг нь төвийн захирлаар батлуулсан ажлын төлөвлөгөөтэй ажиллана.

4.3. Төвийн хүний нөөцийг хөгжүүлэх стратегийн хэрэгжилтийг хоёр жилд нэг удаа үнэлж, үр дүнг хамт олны хурлаар хэлэлцүүлнэ. Тайланг удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж дүгнэлтийг дараагийн жилийн төлөвлөлтөнд ашиглаж, хэвшүүлнэ.

4.4. Шаардлагатай тохиолдолд төвийн захирлын тушаалаар явцын хяналт үнэлгээг зохион байгуулж, нэмэлт өөрчлөлт оруулна.

## ГЕРОНТОЛОГИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ХҮНИЙ НӨӨЦИЙН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ

| Бодлогын баримт бичигт тусгагдсан, болон үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх зорилт | Стратеги /арга зам/ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | | | | Санхүүгийн эх үүсвэр |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | 2023 он | 2024 он | 2025 он | 2026 он | |
| Зорилго: Хүний нөөцийн бодлогыг оновчтой хэрэгжүүлэх замаар Геронтологи гериатрийн салбарын үйл ажиллагааг олон улсын жишигт ойртуулах мэргэжлийн ур чадвар бүхий ажилтнуудыг бүрдүүлэн тогтвор суурьшилтай сэтгэл хангалуун ажиллах нөхцлийг бүрдүүлж, ажлын байран дээрээ өсөж дэвших боломжоор хангахад оршино. | | | | | | | | |
| Зорилт 1. Хүний нөөцийн төлөвлөлт, бүрдүүлэлт, мэргэжлийн залгамж халааг бэлтгэх, тогтвортой ажиллуулах | 1.1 Төвд ажилтныг ажилд авах, сонгон шалгаруулах үйл ажиллагааг ил тод, нээлттэй явуулах нийтлэг журмыг баталж мөрдүүлнэ | Батлагдсан журам Журмын хэрэгжилтийн хувь | Журам боловсруулагдсан боловч хэрэгжилт хангалтгүй. Шинэчлэх шаардлагатай. | Шинэ эмнэлгийн үйл ажиллагаанд нийцсэн журмыг шинэчлэн боловсруулагдсан байна.<br>Жил бүр хэрэгжилтийн үнэлгээ хийгдэж шаардлатай шинэчлэлт хийгдсэн байна. | | | | Үйл ажиллагааны хүрээнд |
| | 1.2 Төвийн ажилтнуудтай байгуулсан хөдөлмөрийн гэрээг холбогдох талуудтай хамтран тогтмол хугацаанд үнэлж, шинэчлэнэ; | Хөдөлмөрийн гэрээний үнэлэлт, шинэчлэлт | 2021 онд хөдөлмөрийн гэрээний үнэлгээ хийгдсэн. 2022 оны Хөдөлмөрийн гэрээг шинэчлэн боловсруулсан. | Жил бүр хэрэгжилтийн үнэлгээ хийгдэж шаардлатай шинэчлэлт хийгдсэн байна. | | | | Үйл ажиллагааны хүрээнд |

48

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 1.3 Шинэ эмнэлгийн барилгад ажиллах хүний нөөцийн тоо хэмжээг тодорхойлон бүрдүүлэх арга хэмжээг авч холбогдох дээд байгууллагад хянуулан хэрэгжилтийг хангаж ажиллана | Хүний нөөцийн тоо хэмжээ, түүний хангалтын хувь хэмжээ | 247 орон тоотойгоор төлөвлөн Эрүүл мэндийн яаманд хүргүүлсэн. | Хүний нөөцийн хангалт 60 хувь бүрдсэн байна | Хүний нөөцийн хангалт 70 хувь бүрдсэн байна | Хүний нөөцийн хангалт 75 хувь бүрдсэн байна | Хүний нөөцийн хангалт 80 хувь бүрдсэн байна | Улсын төсөв ЭМДС ДЭМБ |
| | 1.4 Эмч эмнэлгийн мэргэжилтэн албан хаагчдыг бэлтгэх, дадлагажуулах, давтан сургах замаар залгамж халаа бэлтгэнэ | Дадлагажуулсан | | | | | | |
| | 1.5 Ажилтнуудын сэтгэл ханамжийн судалгааг нээлттэй болон хаалттайгаар тогтмол хугацаанд авч дэвшүүлсэн санал санаачлага, асуудлыг удирдлагын түвшинд шийдвэрлэнэ | | | | | | | |
| Зорилт 2. Хүний нөөцийн сургалт, | 1.1.2.1. Ажлын хажуугаар мэдлэг боловсролоо дээшлүүлж байгаа | Зохион байгуулсан үйл ажиллагаан- | "Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг | 2 удаагийн хэлэлцүүлэг, уулзалт, төрийн болон | 2 удаагийн хэлэлцүүлэг, уулзалт, төрийн болон | 2 удаагийн хэлэлцүүлэг, уулзалт, төрийн болон | 2 удаагийн хэлэлцүүлэг, уулзалт, төрийн | Улсын төсөв ЭМДС ДЭМБ |

49

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| хөгжлийн бодлогыг тасралтгүй, үе шаттай хэрэгжүүлэх | ажилтнуудыг дэмжих, суралцах нөхцөл боломжийг бүрдүүлнэ | ы тайлан | хөгжүүлэхэд тулгамдаж буй асуудал" 2 удаагийн цахим уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулсан. | төрийн бус байгууллагууд хамрагдсан байна. | төрийн бус байгууллагууд хамрагдсан байна. | төрийн бус байгууллагууд хамрагдсан байна. | болон төрийн бус байгууллагууд хамрагдсан байна. | |
| | 1.1.2.2. Ажилтнуудын хөгжлийг дэмжиж, үе шаттайгаар хангаж мэргэжлийн зэрэг, магистр, доктор цолтой ажилтнуудын хувийн жинг жил бүр тогтмол нэмэгдүүлнэ | Хүнсний дэмжлэгт хамруулсан настны тоо | Эрүүл насжилт настны эрүүл мэнд хөтөлбөрийн эцсийн дүгнэлтээр үндэсний хэмжээнд хоол тэжээлийн доройтолд орох эрсдэлтэй настан 24.2 хувь, хоол тэжээлийн доройтол 3 хувь байна. | 100 настанд доройтлын үнэлгээ хийж хүнсний дэмжлэгт хамруулсан байна. | 250 настанд доройтлын үнэлгээ хийж хүнсний дэмжлэгт хамруулсан байна. | 500 настанд доройтлын үнэлгээ хийж хүнсний дэмжлэгт хамруулсан байна. | 1000 настанд доройтлын үнэлгээ хийж хүнсний дэмжлэгт хамруулсан байна. | Улсын төсөв ЭМДС ДЭМБ |
| | Төвийн шинэ ажилтныг хамт олонд танилцуулах, ажлын байранд дадлагажуулах сургалтыг зохион байгуулж хэвшинэ | | | | | | | |
| | Ажилтнуудын англи | | | | | | | |

50

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хэлний мэдлэгийг дээшлүүлэхэд чиглэсэн сургалтыг жил бүр үе шаттайгаар зохион байгуулна | | | | | | | |
| | 1.1.2.3. Төв нь ажилтан бүрийн ойрын болон дунд хугацаанд өөрийгөө хөгжүүлэх төлөвлөгөөний дагуу ур чадвар, туршлагыг үнэлж, тэднийг сургах, хөгжүүлэх нэгдсэн төлөвлөгөөг жил бүр гарган хэрэгжүүлнэ | Хамрагдсан настны тоо | 2020 оны Насны доройтлын тархалтын судалгаа | 600 настанд доройтлын түвшин тодорхойлж эрт илрүүлэг, хяналтын тогтолцоонд оруулсан байна. | 1000 настанд доройтлын түвшин тодорхойлж эрт илрүүлэг, хяналтын тогтолцоонд оруулсан байна. | 1500 настанд доройтлын түвшин тодорхойлж эрт илрүүлэг, хяналтын тогтолцоонд оруулсан байна. | 2000 настанд доройтлын түвшин тодорхойлж эрт илрүүлэг, хяналтын тогтолцоонд оруулсан байна. | Улсын төсөв ЭМДС ДЭМБ |
| | 1.1.2.4. Дотоод сургалтыг төрөлжүүлж, сэдэв хөтөлбөрийг жил бүр шинэчлэнэ | Хамрагдсан байгууллагуудын тоо | Эрүүл мэндийн байгууллагуудын чанар сайжруулах COPE үнэлгээгээр настанд ээлтэй орчин бүрдүүлэх чиглэлээр нийслэлийн 144 ӨЭМТ-г үнэлж зөвлөгөө | 40 ААН, 110 ӨЭМТ-д үнэлгээ хийж, настанд ээлтэй орчин бүрдүүлэх чиглэлээр мэргэжил аргазүйн зөвлөгөө өгсөн байна. Настанд ээлтэй ААН, ӨЭМТ шалгаруулж урамшуулсан байна. | 50 ААН, 120 ӨЭМТ-д үнэлгээ хийж, настанд ээлтэй орчин бүрдүүлэх чиглэлээр мэргэжил аргазүйн зөвлөгөө өгсөн байна. Настанд ээлтэй ААН, ӨЭМТ шалгаруулж урамшуулсан байна. | 60 ААН, 130 ӨЭМТ-д үнэлгээ хийж, настанд ээлтэй орчин бүрдүүлэх чиглэлээр мэргэжил аргазүйн зөвлөгөө өгсөн байна. Настанд ээлтэй ААН, ӨЭМТ шалгаруулж урамшуулсан байна. | 70 ААН, 140 ӨЭМТ-д үнэлгээ хийж, настанд ээлтэй орчин бүрдүүлэх чиглэлээр мэргэжил аргазүйн зөвлөгөө өгсөн байна. Настанд ээлтэй ААН, ӨЭМТ шалгаруулж урамшуулса | Улсын төсөв ЭМДС ДЭМБ |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | өгсөн. | | | | н байна. | |
| | Эмнэлгийн мэргэжилтний зайн сургалтын хэрэгцээний судалгааг хийнэ | | | | | | | |
| | Улсын төсөв, олон улсын төсөл, хөтөлбөрийн санхүүжилтээр гадаадын өндөр хөгжилтэй оронд эмч, сувилагч, мэргэжилтнүүдийг сургалтанд хамруулах тоог нэмэгдүүлнэ | | | | | | | |
| | 1.1.2.5. Төвийн номын сангийн үйл ажиллагааг өргөжүүлнэ | Тогтмол баяжилт хийсэн мэдээдлийн сан | Байхгүй | Доройтлын тархалтын цахим мэдээллийн сан үүссэн байна. | Доройтлын тархалтыг үнэлэх аргачлал боловсруулагд-сан байна. | Доройтлыг үнэлэх аргачлалд үндэслэсэн мэдээллийн сангийн программ боловсруулсан байна. | Доройтлыг мэдээллээс бүрдсэн дата санг үүсгэсэн байна. | Байгуул-лагын төсөв, төсөлт хөтөлбөр |
| Зорилт 3. Ажлын гүйцэтгэлийн удирдлага, зохион байгуулалтыг оновчтой болгох | 1.1.3.1. Ажлын бодит гүйцэтгэл, ил тод байдал, урамшууллыг оновчтой уялдуулах механизмыг хэрэгжүүлнэ | Төлөвлөгөө-ний хэрэгжилтийн хувь | Геронтологийн үндэсний төвийн ерөнхий захирлын 2021 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн тушаалаар 2 удаагийн тодотгол хийж | Тухай бүрт тодотгол хийж батлуулж, 100 хувь хэрэгжүүлсэн байна. | Тухай бүрт тодотгол хийж батлуулж, 100 хувь хэрэгжүүлсэн байна. | Тухай бүрт тодотгол хийж батлуулж, 100 хувь хэрэгжүүлсэн байна. | Тухай бүрт тодотгол хийж батлуулж, 100 хувь хэрэгжүүлсэн байна. | Байгуул-лагын төсөв |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | батлуулсан ТУТ-ны төлөвлөгөөг 95.1 хувь хэрэгжүүлсэн байна. | | | | | |
| | 1.1.1.3.2. Ажлын гүйцэтгэлийн үнэлгээ хийх арга аргачлалыг жил бүр үнэлэж, сайжруулах арга хэмжээ авч ажиллана | Хамрагдсан ахмад настны тоо | Нийслэлийн 7 дүүргийн 6874 настанд 4 удаагийн эргэлтээр настны цогц тусламж үйлчилгээ үзүүлсэн. | 2400 настанд настны цогц тусламж үйлчилгээ үзүүлсэн байна. | 400 настанд настны цогц тусламж үйлчилгээ үзүүлсэн байна. | - | - | Байгуул-лагын төсөв<br><br>ДЭМБ-ын төсөл, хөтөлбөр |
| | Ажилтнуудын ажлын ачаалал болон ажлын үр дүнг бодитой үнэлнэ | | | | | | | |
| Зорилт 4. Цалин хөлс, шагнал, урамшууллын системийг боловсронгуй болгох | 1.2.1.1. Эрүүл мэндийн ажилтны гүйцэтгэлийг үнэлэх шалгуурыг боловсронгуй болгоно. | Үйл ажиллагааны удирдамжийн хэрэгжилтийн хувь | ДЭМБ-ын Настны цогц тусламж үйлчилгээний удирдамж 2019 он. | Настны цогц тусламж үйлчилгээний удирдамжийг шинэчлэн боловсруулж Геронтологийн үндэсний төвд хэрэгжүүлсэн байна. | Нийслэл орон нутагт Настны цогц тусламж үйлчилгээний удирдамжийг нэвтрүүлж эхэлсэн байна. Ажлын явц 50 хувьтай байна. | Нийслэл орон нутагт Настны цогц тусламж үйлчилгээний удирдамжийг нутагшуулсан байна. Ажлын явц 75 хувьтай байна. | Нийслэл орон нутагт Настны цогц тусламж үйлчилгээний удирдамжийг хэрэгжилтийг хангаж ажилласан байна. Ажлын явц 100 хувьтай байна. | Байгуул-лагын төсөв |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 1.2.1.3. Төрийн албаны ангилал зэрэглэлийн шатлал дэвшүүлэх журмыг боловсруулж хэрэгжүүлнэ | Урт хугацааны тусламж үйлчилгээнд хамрагдсан настнуудын тоо | Төрөлжсөн мэргэшлийн тусламж үйлчилгээг эмзэг бүлгийн настнуудад гэрээр Олон мэргэжлийн багаар хүргэж байна. | Урт хугацааны тусламж үйлчилгээнд 500 настанг хамруулсан байна. | Урт хугацааны тусламж үйлчилгээнд 600 настанг хамруулсан байна. | Урт хугацааны тусламж үйлчилгээнд 700 настанг хамруулсан байна. | Урт хугацааны тусламж үйлчилгээнд 800 настанг хамруулсан байна. | Байгуул-лагын төсөв |
| | 1.2.1.4. Эрүүл мэндийн ажилтны төрсөн аав, ээж, эхнэр (нөхөр), үр хүүхэд зэрэг гэр бүлийн аль нэг гишүүнд жилд нэг удаа эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хөнгөлттэй үзүүлэх боломжийг судлан, шийдвэрлэнэ | Үйлчлүүлэгчийн тоо | Өдрийн сэргээн засах, уламжлалт эмчилгээ хийдэг. | Эмийн эмчилгээний нэгж шинээр байгуулж, 300 настанд өдрийн эмийн эмчилгээ хийж үр дүнг тооцсон байна. | Настны дагнасан сэргээн засах тусламж үйлчилгээний хэвтүүлэн эмчлэх тасаг нээж ажиллуулсан байна. 1500 настанд эмчилгээ хийсэн байна. | 1000 настанд уламжлалт анагаах ухааны хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээ үзүүлсэн байна. | Мэс заслын тасаг, идэвхтэй насжилтын төвийг шинээр нээж ажиллуулсан байна. 500 настанд тусламж үйлчилгээ үзүүлсэн байна. | Байгуул-лагын төсөв Хандив тусламж |
| Зорилт 5 Хөдөлмөрийн аюулгүй байдал, ажиллах нөхцөлийг сайжруулах | 1.2.3.1. Геронтологийн үндэсний төвийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль, стандарт, дүрэм, журмын хэрэгжилтийг тогтмол хугацаанд холбогдох талуудтай хамтран | Батлагдсан заавар, удирдамжийн тоо | 2019 онд 5 заавар, 1 стандартыг шинээр боловсруулж, Эрүүл мэндийн сайдын 2019 оны 517 дугаар | Настны эрүүл мэндийн чиглэлээр шинээр 1-2 заавар боловсруулж батлуулсан байна. | Настны эрүүл мэндийн чиглэлээр шинээр 1-2 заавар боловсруулж батлуулсан байна. | Настны эрүүл мэндийн чиглэлээр шинээр 1-2 заавар боловсруулж батлуулсан байна. | Настны эрүүл мэндийн чиглэлээр шинээр 1-2 заавар боловсруулж батлуулсан байна. | Байгуул-лагын төсөв, ДЭМБ-ын санхүү-жилт |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | үнэлэх, шаардлагатай дүрэм, журмыг шинээр болон шинэчлэн баталж мөрдүүлнэ | | тушаалаар баталгаажуулсан | | | | | |
| | 1.2.3.2. Геронтологийн үндэсний төвийн бүр эрүүл мэндийн ажилтныг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага хангасан нэгдсэн загвар бүхий ажлын хувцас, ажлын хэрэгслээр бүрэн хангаж, тогтмол хугацаанд шинэчлэнэ | ОУ-ын эмнэлзүйн платформыг ашиглаж буй эмч мэргэжилтний тоо | Байхгүй | Up-To-Date платформын ашиглалтын аргачлалыг эмч мэргэжилтнүү-дийн 80 хувьд нь эзэмшүүлж, хэрэглээнд нэвтрүүлсэн байна. | Up-To-Date платформын ашиглалтын аргачлалыг эмч мэргэжилтнүү-дийн 85 хувьд нь эзэмшүүлж, хэрэглээнд нэвтрүүлсэн байна. | Up-To-Date платформын ашиглалтын аргачлалыг эмч мэргэжилтнүүдийн 90 хувьд нь эзэмшүүлж, хэрэглээнд нэвтрүүлсэн байна. | Up-To-Date платформын ашиглалтын аргачлалыг эмч мэргэжилтнү ү-дийн 95 хувьд нь эзэмшүүлж, хэрэглээнд нэвтрүүлсэн байна. | Байгуул-лагын төсөв |
| | Геронтологийн үндэсний төвийн удирдах ажилтнуудын хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны талаарх мэдлэгийг сайжруулах | | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | сургалтыг тогтмол зохион байгуулна | | | | | | | |
| | Геронтологийн үндэсний төвийн ослыг тэг байлгах, осол, мэргэжлийн өвчнөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлэх; хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд, хөдөлмөрийн эрүүл ахуйн чиглэлийн сургалт, сурталчилгааг эрүүл мэндийн ажилтнуудад тогтмол зохион байгуулна | | | | | | | |
| Зорилт 6 Эрүүл мэндийн ажилтны эрүүл мэндийг хамгаалах | 1.2.4.1. Эрүүл мэндийн ажилтныг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах, хяналтанд авах, эмчлэн эрүүлжүүлэх журмыг батлан, эрүүл мэндийн байгууллага бүр хэрэгжүүлнэ | Тоног төхөөрөм-жийн хангалтын хувь | MNS6330:2017 Төрөлжсөн мэргэшлийн төвийн бүтэц үйл ажиллагааны стандартын хэрэгжилт 89 хувьтай байна. | MNS6330:2017 Төрөлжсөн мэргэшлийн төвийн бүтэц үйл ажиллагааны стандартын хэрэгжилт 91 хувьтай болсон байна. | MNS6330:2017 Төрөлжсөн мэргэшлийн төвийн бүтэц үйл ажиллагааны стандартын хэрэгжилт 93 хувьтай болсон байна. | MNS6330:2017 Төрөлжсөн мэргэшлийн төвийн бүтэц үйл ажиллагааны стандартын хэрэгжилт 95 хувьтай болсон байна. | MNS6330:2017 Төрөлжсөн мэргэшлийн төвийн бүтэц үйл ажиллагааны стандартын хэрэгжилт 97 хувьтай болсон байна. | Улсын төсвийн хөрөнгө оруулал-таар |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 1.2.4.2. Эрүүл мэндийн ажилтанд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хөнгөлөлттэй үзүүлэх журмыг шинэчлэн баталж мөрдүүлнэ | Шинээр ашиглалтанд оруулсан тоног төхөөрөм-жийн нэр төрөл, тоо | Байхгүй | - | Эмнэлзүйн (гематологийн, шээсний анализатор) лабораторийн аппаратаар хангасан байна. | Биохимийн болон иммунологийн, бактериологийн лабораторийн аппаратаар хангасан байна. | Насжилтын судалгаа эрдэм шинжилгээний ажил хийхэд шаардлагатай багаж тоног төхөөрөмжөөр хангасан байна. | Улсын төсвийн хөрөнгө оруулал-таар |
| | Эрүүл мэндийн байгууллага ажилтнуудаа ажлын байранд сэтгэл зүйн зөвлөгөө, тусламж, үйлчилгээ авах боломжоор хангана. | | | | | | | |
| **Зорилт 7 Ажилтнуудын нийгмийн баталгааг хангах** | Эрүүл мэндийн ажилтны нийгмийн хамгааллын чиглэлийн судалгааг тогтмолжуулж өргөжүүлнэ | | | | | | | |

57

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Геронтологийн үндэсний төв нь албан үүргээ гүйцэтгэж байх үедээ заналхийлэл, хүчирхийлэлд өртсөн эрүүл мэндийн ажилтныг хууль эрх зүйн туслалцаа авахад дэмжлэг үзүүлнэ | | | | | | | |
| | Жил бүр ажилтны нийгмийн хамгааллыг дэмжих үйл ажиллагааг төвийн хүний нөөцийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлнэ | | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Хууль тогтоомжид заагдсан бүх нэмэгдэл урамшуулал, хөнгөлөлтийн хэмжээг улсын дундажаас доор оруулалгүй тухай бүр шинэчлэн нэмэгдүүлнэ | | | | | | | |
| | Гэр болон галлагаатай байшинд амьдардаг албан хаагчдад түлээ, нүүрс худалдан авахад байгууллагын зүгээс дэмжлэг үзүүлнэ | | | | | | | |
| | Албан хаагчдыг ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгохоос гадна мөнгөн бус урамшууллын аливаа аргыг судлан хууль | | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | тогтоомжид нийцүүлэн урамшуулна | | | | | | | |
| | Шинэ гэр бүл болох, бүл нэмэх, Төр засгийн шагналаар шагнуулах зэрэг албан хаагчдад баярт үйл явдал тохиолдоход байгууллагаас баярын үйл ажиллагааг санаачлан зохион байгуулах, эд хөрөнгийн болон мөнгөн тусламж олгоно. | | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Ар гэрт нь гачигдал гарах, гэр бүлийн ойрын гишүүн гэрлэх, сургууль төгсөх, диплом эрдмийн зэрэг хамгаалах зэрэг хүндэтгэн үзэх шалтгаантай тохиолдолд байгууллагаас цалинтай чөлөө олгоно | | | | | | | |
| Зорилт 8 Геронтологи, гериатрийн чиглэлээр мэргэшсэн хүний нөөц бэлтгэх, мэргэшил, арга зүйгээр хангах | 2.1.1.1. Геронтологийн үндэсний төвийн хүний нөөцийн хөгжлийн төлөвлөгөө 2021-2024 боловсруулж хэрэгжүүлнэ. | Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь | Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр 2017-2020 хэрэгжилт 85.1 хувьтай байсан | Төлөвлөгөө батлуулсан байна. Хэрэгжилт 90 хувь биелсэн байна. | Хэрэгжилт 92 хувь биелсэн байна. | Хэрэгжилт 95 хувь биелсэн байна. | Хэрэгжилт 100 хувь биелсэн байна. | Байгууллагын төсөв |
| | 2.1.1.2. Үндэсний хэмжээнд мэргэшсэн эмч мэргэжилтэнг бэлтгэж бүрэн орон тоогоор ажиллуулахад хамтран ажиллана. | Хамрагдсан эмч мэргэжилтний тоо | Эрүүл мэндийн сайдын А/311 тушаалаар батлагдсан настны кабинетийн үлгэрчилсэн дүрэм, нийслэлд 2 | Настны кабинетын үлгэрчилсэн дүрмийг шинэчлэн батлуулна. | Настны эрүүл мэндийн цогц үнэлгээний удирдамж шинэчлэн боловсруулж батлуулсан байна. Нийслэлийн 4 дүүрэг, орон | Нийслэлийн 6 дүүрэг, хөдөө орон нутгийн 18 аймагт гериатрийн эмч мэргэжилтэнг мэргэшүүлэн ажиллуулсан байна. | Нийслэлийн 9 дүүрэгт, хөдөө орон нутгийн 21 аймагт гериатрийн эмч мэргэжилтэнг мэргэшүүлэн | Байгууллагын төсөв |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | дүүрэг, орон нутагт 13 аймагт мэргэшсэн настны эмч бэлтгэгдсэн байна. | | нутгийн 16 аймагт гериатрийн эмч мэргэжилтэнг мэргэшүүлэн ажиллуулсан байна. | | ажиллуулсан байна. | |

# ГЕРОНТОЛОГИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ӨНӨӨГИЙН ОРОН ТОО БОЛОН ШИНЭ ЭМНЭЛЭГТ ШААРДЛАГАТАЙ ОРОН ТОО

| Алба, тасаг, нэгж | Албан тушаал | Орон тоо | Одоо байгаа оронтоо |
|---|---|---|---|
| Захирлууд | Ерөнхий захирал | 1 | 1 |
| | Эмнэлзүй эрхэлсэн дэд захирал | 1 | 1 |
| | Үйл ажиллагаа эрхэлсэн дэд захирал | 1 | 0 |
| дотоод хяналт | Дотоод аудит хяналт шинжилгээний мэргэжилтэн | 1 | 1 |
| ЭМТҮ-ний чанар аюулгүй байдлын алба | Албаны дарга | 1 | 1 |
| | Чанарын менежер | 2 | 0 |
| | Тархвар судлаач | 1 | 1 |
| | Эрсдлийн менежер | 2 | 0 |
| Амбулаторийн кабинетууд | Амбулаторийн эрхлэгч | 1 | 0 |
| | Настны эмч | 2 | 1 |
| | Зүрх судасны эмч | 1 | 1 |
| | Сэтгэцийн эмч | 1 | 0 |
| | Нүдний эмч | 1 | 1 |
| | Чих хамар хоолойн эмч | 1 | 0 |
| | Мэдрэлийн эмч | 1 | 1 |
| | Дотоод шүүрлийн булчирхайн эмч | 1 | 0 |

| | | | |
|---|---|---|---|
| | Хоолны эмч | 1 | 0 |
| | Сэргээн засахын эмч | 2 | 2 |
| | Арьс харшлын эмч | 1 | 1 |
| | Урологи эмч | 1 | 0 |
| | Хавдар судлалын эмч | 1 | 0 |
| | Сэтгэл заслын эмч | 1 | 0 |
| | Уламжлалтын эмч | 1 | 1 |
| | Эмэгтэйчүүдийн эмч | 1 | 0 |
| | Хөнгөвчлөх эмчилгээний эмч | 1 | 0 |
| | Зүү төөнүүрийн эмч | 1 | 1 |
| | Шүдний эмч | 2 | 0 |
| | Хөдөлмөр засалч | 2 | 0 |
| | Хөдөлгөөн засалч | 2 | 1 |
| | Сувилагч | 20 | 4 |
| | Зохион байгуулагч | 2 | 0 |
| | Лавлагаа мэдээллийн ажилтан | 1 | 0 |
| Оношлогоо | Уян дурангийн эмч | 1 | 0 |
| | Хэт авиан оношлогоон эмч | 4 | 1 |
| | Эмэгтэйчүүдийн эхо | 1 | 0 |
| | Компьютер томографийн эмч | 1 | 0 |
| | Рентгений эмч | 1 | 0 |
| | Тархины цахилгаан бичлэгийн эмч | 1 | 1 |
| | Зүрхний эхоны эмч | 1 | 1 |
| | Ясны нягтралын тодорхойлох оношлогооны эмч | 1 | 0 |
| | MRI эмч | 1 | 0 |
| | Зүрхний цахилгаан бичлэгийн эмч | 1 | 0 |
| | Сувилагч | 12 | 2 |

| | | | |
|---|---|---|---|
| | Техникч | 7 | 0 |
| Лаборатори | Эмч | 1 | 0 |
| | Лаборант | 4 | 0 |
| | Туслах ажилтан | 2 | 0 |
| Олон мэргэжилийн баг | Настаны эмч | 1 | 0 |
| | Нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтэн, | 1 | 1 |
| | Настаны сувилагч | 2 | 0 |
| Стационар | Тасгийн эрхлэгч | 3 | 0 |
| | Их эмч | 7 | 0 |
| | Сувилагч | 17 | 0 |
| настаны хөгжлийн төв | Албаны дарга | 1 | 0 |
| | Клиникийн дархлаа судлаач эмч | 1 | 0 |
| | Биеийн тамирын аргазүйч | 1 | 0 |
| | Хоол зүйч | 1 | 0 |
| | Клиник эм судлаач | 1 | 0 |
| Сувилахуй эрхэлсэн алба | Албаны дарга | 1 | 0 |
| | Сувилахуйн арга зүйч | 2 | 0 |
| Ариутгал, халдваргүйтгэлийн тасаг | Тасгийн эрхлэгч | 1 | 0 |
| | Автоклавчин | 1 | 0 |
| | Ариутгагч | 2 | 0 |
| | Угаагч /цагаан хэрэгсэл/ | 2 | 1 |
| | Индүүчин | 1 | 0 |
| Эм зүйн алба | Албаны дарга | 1 | 0 |
| | Эм олгогч, эд хариуцагч, /эм найруулагч/ | 1 | 0 |
| | Эм найруулагч | 1 | 0 |
| | эм зүйч | 1 | 1 |
| | Шил угаагч | 1 | 0 |

| | | | |
|---|---|---|---|
| Үйлчлүүлэгчийг дэмжих алба | асрагч | 6 | 0 |
| | туслах сувилагч | 3 | 0 |

| | | | |
|---|---|---|---|
| Сургалт, эрдэм шинжилгээ, хамтын ажиллагааны алба | Албаны дарга | 1 | 1 |
| | Судалгаа | 4 | 2 |
| | Сургалт | 2 | 2 |
| | Гадаад харилцаа, хамтын ажиллагаа | 1 | 1 |
| | Хэвлэлийн эх бэлтгэлийн ажилтан | 1 | 0 |
| | Номын санч | 1 | 0 |
| | Олон нийттэй харилцах, хэвлэл мэдээллийн ажилтан, маркетинг хариуцсан мэргэжилтэн | 1 | 0 |
| Статистик, мэдээллэлийн алба | Даатгалын эмч, Тасгийн эрхлэгч | 1 | 1 |
| | Даатгалын бага эмч | 1 | 0 |
| | Цахим бүртгэгч | 3 | 1 |
| | Статистикч их эмч | 1 | 0 |
| | Статистикч бага эмч | 1 | 1 |
| Хүний нөөцийн хөгжлийн алба | Албаны дарга | 1 | 0 |
| | Хүний нөөцийн мэргэжилтэн | 1 | 1 |
| | Бичиг хэргийн эрхлэгч, даргын туслах | 1 | 1 |
| | Архивын эрхлэгч | 1 | 1 |
| | Хуулийн зөвлөх/ Хуулийн эрхзүйн мэргэжилтэн | 1 | 0 |
| | Төлөвлөлт биелэлт хариуцсан мэргэжилтэн | 1 | 0 |
| Санхүү бүртгэлийн алба | Албаны дарга | 1 | 0 |
| | Ахлах нягтлан бодогч | 1 | 1 |

| | | | |
|---|---|---|---|
| | Эдийн засагч | 1 | 1 |
| | Цалингийн нягтлан | 1 | 0 |
| | Үндсэн хөрөнгийн нягтлан бодогч | 1 | 0 |
| | Эм,эмнэлэгийн хэрэгсэлийн нягтлан бодогч | 1 | 0 |
| | Нярав | 2 | 1 |
| Мэдээллийн технологийн алба | Албаны дарга / | 1 | 0 |
| | Сүлжээний инженер | 2 | 1 |
| | Программ хангамжийн инженер | 1 | 0 |
| | Мэдээлэл технологийн инженер | 1 | 0 |
| | Сүлжээний администратор | 1 | 0 |
| Инженер техникийн алба | Албаны дарга/ Ерөнхий инженер | 1 | 0 |
| | Тоног төхөөрөмжийн инженер | 1 | 0 |
| | Техник хангамжийн инженер | 1 | 0 |
| | Хүчилтөрөгчийн ажилтан | 1 | 0 |
| | Гемодиализийн инженер | 1 | 0 |
| Аж ахуй, хангалт үйлчилгээний алба | Албаны дарга, менежер | 1 | 1 |
| | Харуул | 4 | 3 |
| | Үйлчлэгч | 27 | 2 |
| | Слесарь | 2 | 1 |
| | Лифтчин | 1 | 0 |
| | Гагнуурчин | 1 | 0 |
| | Цахилгаанчин | 1 | 0 |
| | Мужаан | 1 | 0 |
| | Жолооч | 3 | 2 |
| Эмнэлгийн хоол, шим тэжээлийн алба | Ахлах тогооч, Хоолны технологич | 1 | 0 |
| | Тогооч | 1 | 0 |
| | Угаагч /гал тогоо/ | 1 | 0 |

67

| | | | |
|---|---|---|---|
| | Бэлтгэгч | 2 | 0 |
| | | 247 | 52 |